



БЯАН-ӨЛГИЙ АЙМАГ
ДЭЛҮҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 7/144


Рашаант

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээний цэцэрлэгийн насны хүүхдүүдийн судалгааг гаргаж, цэцэрлэгт хамрагдсан байдал, оршин сууж байгаа газрын хаягийг тогтоох, нас насаар нь ангилах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Цэцэрлэгийн насны хүүхдийн судалгааг гаргахад багийн Засаг дарга нартай нягт холбоотой ажиллаж, үнэн зөв мэдээлэл гаргаж аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын холбогдох мэргэжилтэнд уламжлан ажиллахыг үүрэг болгосугай.
3. Хийсэн ажлын тайланг Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

ДАРГА



Б.СЕРИКБОЛ